

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ЭЗЭМШИЛ, ӨМЧЛӨЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

2026.03.26-ны өдөр

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, 19 дүгээр зүйлийн 19.5-д заасан чиг үүргийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшил болон эзэмшлийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр шинэчлэн гаргаж, олон нийтэд тогтмол мэдээлдэг.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний эзэмшлийг ил тод байдлыг хангах тодорхой зохицуулалтуудыг тусгасан байдаг. Тухайлбал:

- *“Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгана.” (19.1 дэх хэсэг);*
- *“Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Зохицуулах хороонд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх тус хуульд заасан мэдээллийг хүргүүлнэ” (19.2 дах хэсэг);*
- *“Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх мэдээллийг Зохицуулах хороо олон нийтэд мэдээлнэ”(19.5);*
- *Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллийг Зохицуулах хороонд гаргаж өгөөгүй, нуусан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авна” (19.6) гэж тус тус заасан байдаг.*

Харилцаа холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн мэдээллийг 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар шинэчлэн гаргаж, олон нийтэд мэдээлсэн.

Тус мэдээлэлд үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн компанийн эзэмшил, өмчлөлийн талаарх нэгдсэн мэдээллийг хүргэж байна.

Хүснэгт 1. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн төрөл, тоо (2025.12.31)

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн төрөл (Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6.1)	Үйлчилгээ эрхлэх байршлаар	
	Улаанбаатар хот	Орон нутаг
Монголын үндэсний олон нийтийн радио телевиз	9	-
Өргөн нэвтрүүлгийн телевиз	18	38
Арилжааны телевиз	55	3
Төлбөртэй телевиз	20	-
Радио	30	34
Олон суваг дамжуулах үйлчилгээ	11	14
Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх	1	-
НИЙТ	233	

Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 233 үйлчилгээ эрхлэгчийг харьяаллаар нь авч үзвэл:

- Монголын үндэсний олон нийтийн радио, телевизэд 9 тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ (үндсэн 2 суваг болон түүний харьяа бусад сувгууд);
- улсын төсөвт байгууллага болон төрийн өмчит үйлдвэрийн газарт харьяалагдах 2 үйлчилгээ эрхлэгч;
- 222 үйлчилгээ эрхлэгч нь хувийн өмчийн хэлбэртэй, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй байна.

Нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс **153** үйлчилгээ эрхлэгч эзэмшлийн мэдээллээ батлагдсан маягтын дагуу, хуульд заасан хугацаанд ирүүлжээ.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн мэдээллийг хүлээн авч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын нээлттэй мэдээллийн сан (opendata.mn) -гийн мэдээлэлтэй тулган шалгасны үндсэн дээр эзэмшлийн мэдээллийг эцэслэн гаргасан болно.

- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллийг 2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар авч үзэхэд:

Хүснэгт 2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх зүйн статус

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид нийт тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх зүйн статус							
	НЭЗХЭ (Олон нийтийн)	УТҮГ	ТӨҮГ	ХХК	ТББ	ХМБ*	ШБ*	Иргэн
233	9	1	1	181	15	2	1	1

*Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.2-т “өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно”. гэж заасан байдаг.

Тайлбар: ХМБ* - Хэвлэл мэдээллийн байгууллага, ШБ* - Шашны байгууллага

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1-р зүйлд “Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө (2020 оны 7-р сарын 1-нээс өмнө) улсын бүртгэлд бүртгүүлж, зохих журмын дагуу үйл ажиллагаа явуулж байсан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх хүчин төгөлдөр байна.” гэж заасан болно.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хэлбэрийг авч үзэхэд 90,5% нь Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэр дээр байна.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллийг 2025 оны байдлаар шинэчлэн авч үзэхэд дараах өөрчлөлтүүд бүртгэгдсэн. Үүнд:

Хүснэгт 3. Эзэмшлийн өөрчлөлтийн нэгдсэн хүснэгт

Өөрчлөлтийн төрөл	Тусгай зөвшөөрлийн ангилал	Өөрчлөлтийн тоо (2025)
Хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт	УБ. Өргөн нэвтрүүлгийн телевиз (18 телевизээс)	2
	УБ. Арилжааны телевиз (55 телевизээс)	7
	Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз (41 телевизээс)	2
	Радиоогийн үйлчилгээ	УБ Радио-4
	Төлбөртэй телевиз	1
	Олон суваг дамжуулах үйлчилгээ	0
Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд	Өргөн нэвтрүүлгийн телевиз	2
	Улаанбаатар хот. Арилжааны телевиз	6
	Орон нутгийн телевиз	1
	Радио	УБ- 4

2025 оны эцсийн байдлаар өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн өөрчлөлтийг үйлчилгээний төрлөөр авч үзвэл, Улаанбаатар хотын арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн дунд өмчлөлийн бүтцэд болон хувьцаа эзэмшигч, удирдлагын өөрчлөлт бусад ангиллаас харьцангуй өндөр байна. Энэ нь тухайн ангилалд хөрөнгө оруулалтын хөдөлгөөн, өмчлөлийн шилжилт илүү идэвхтэй байгааг харуулж буй юм. Харин олон суваг дамжуулах үйлчилгээний хувьд эзэмшлийн бүтэц харьцангуй тогтвортой, бусад ангилалд эзэмшлийн өөрчлөлтийн түвшин бага байна.

Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшил, өмчлөлийн нэгдсэн мэдээлэл

1. Өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн байдал

Хүснэгт-4. Өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдийн эзэмшлийн бүтэц, ангилал, тайлбар

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч ХХК-ийн эзэмшлийн бүтэц	Тайлбар	Телевизийн тоо	Телевизийн нэр
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй	Компани тус бүрийг нэг иргэн дангаар 100% эзэмшдэг	6	TB5, SBN, Star, ETV, Малчин, Сүлд
2	Компани тус бүр олон иргэний хамтарсан эзэмшилтэй	Компани тус бүрд 2 ба түүнээс дээш иргэн хувьцаа эзэмшдэг	4	25-р суваг, UBS, TM, Central
3	Компани тус бүрийг 1 хуулийн этгээд (ХХК)100% эзэмшдэг	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг өөр нэг ХХК 100% эзэмшдэг	6	TV8, C1, TB9, NTV, Eagle, Боловсрол суваг
4	Иргэн, ХК-ийн холимог эзэмшилтэй	Эзэмшигчдийн бүрэлдэхүүнд иргэн болон хувьцаат компани хамт орсон	1	Монгол ТВ
5	ХК, ХХК холимог олон хуулийн этгээдийн эзэмшилтэй	2 ба түүнээс дээш хуулийн этгээдээс бүрдсэн холимог эзэмшлийн бүтэцтэй.	1	TenGer TV

Хүснэгт 5. Өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшлийн бүтцийн ангилал

№	Эцсийн эзэмшлийн ангилал	Тоо	Телевизүүд
1	Компани тус бүр нэг иргэний эцсийн эзэмшилтэй (шууд болон дам эзэмшлээр 100%)	11	TB5, SBN, Star, ETV, Малчин, Сүлд, TV8, C1, TB9, Eagle, Боловсрол суваг
2	Компани тус бүр олон этгээдийн хамтарсан эзэмшилтэй	5	25-р суваг, UBS, TM, Central, NTV
3	Компани тус бүр иргэн болон ХХК олон хуулийн этгээдийн холимог эзэмшилтэй (ХК, Иргэн, ХХК)	2	Монгол ТВ, TenGer TV

Өргөн нэвтрүүлгийн 18 телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдээс 11 компани буюу 61% нь **тус бүр** нэг иргэний эзэмшлийн бүтэцтэй байгаа нь өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хувьд нэг этгээдийн эзэмшил харьцангуй өндөр байгааг харуулж байна. Иймд компанийн засаглалыг сайжруулах хүрээнд удирдлага, хувьцаа эзэмшигч, редакц, дотоод хяналтын чиг үүргүүдийн зохистой зааг харилцааг тодорхой болгох, мэдээллийн ил тод байдал, редакцын хараат бус байдлыг хангах асуудлыг цаашид анхаарч авч үзэх шаардлагатай.

Үлдсэн 7 телевизийн хувьд эзэмшлийн бүтэц нь хоёр ба түүнээс дээш этгээдийн оролцоотой бөгөөд иргэн, хуулийн этгээд, нээлттэй хувьцаат компанийн оролцоо бүхий холимог хэлбэртэй байна. Ийм бүтэц нь өмчлөлийн оролцоог өргөжүүлэх, хяналтын механизмыг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт татах, санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх давуу талтай.

Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн тусгай зөвшөөрлийн эзэмшигчдийн дунд нээлттэй хувьцаат компанийн оролцоо бий болсон нь санхүүгийн тайлагнал, дотоод хяналт, үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах замаар компанийн засаглалд эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдэж байгааг харуулж байна.

Компанийн хөрөнгийн ихэнх нь олон жижиг хувьцаа эзэмшигчдэд тараан хуваарилагдах нь өөрөө компанийн засаглалын эерэг үзүүлэлт байдаг учраас олон улсын зах зээл дээр ийм эзэмшлийн бүтэцтэй компанид хүмүүс хөрөнгө оруулалт хийх дуртай байдаг. Эзэмшил төвлөрсөн компанид хөрөнгө оруулалт хийх нь эргээд гүйцэтгэх удирдлагад хяналт тавих болон компанийн удирдлагад оролцох боломж бололцооны тал дээр хязгаарлагдмал байдаг бөгөөд эзэн агентын зөрчил гэхээс илүү том хувьцаа эзэмшигчид болон жижиг хувьцаа эзэмшигчдийн зөрчил ихтэй байдаг. (Т.Цэнд-Аюуш, 2011, хууд. 142)

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 7.4.6-д гадаадын хөрөнгө оруулагч этгээдэд өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон байдаг. Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллээс үзэхэд өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрлийн эзэмшил нь дотоодын иргэн, хуулийн этгээдийн оролцоонд тулгуурласан байна.

2. Арилжааны телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн байдал

Хүснэгт-6. Арилжааны телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эзэмшлийн бүтэц

№	ХХК-ийн эзэмшлийн бүтэц	Телевизийн тоо
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй	21
2	Компани тус бүр олон иргэний хамтарсан эзэмшилтэй	9
3	Компани тус бүр 1 хуулийн этгээдийн 100% эзэмшилтэй	12
4	Иргэн, ХК-ийн холимог эзэмшилтэй	1
5	ХХК болон ТББ-ын хамтарсан эзэмшилтэй	2
6	Иргэн болон ХХК, ТББ (олон хуулийн этгээдийн холимог эзэмшилтэй)	10

Хүснэгт-7. Арилжааны телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эзэмшлийн бүтэц дэлгэрэнгүй

№	Ангилал	Тайлбар	Телевизийн нэр
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй	Компани тус бүрийг нэг иргэн дангаар 100% эзэмшдэг	Парламентын суваг, Channel11, Өлзий телевиз, ТВ5-2, Тэнгэр, Соён гэгээрүүлэгч, TV3, Moviemax, LIVE, Хөгжил телевиз, Мянгат Malchin, TV6, News channel, Си чаннель, Их засаг, Mongolsat Кино, GU телевиз, Bantan, MNTV, Play Max, Шүүхийн суваг.
2	Компани тус бүр олон иргэний хамтарсан эзэмшилтэй	Компани тус бүрд 2 ба түүнээс дээш иргэн хувьцаа эзэмшдэг	7-р суваг, Eco Channel, Like суваг, Хөх Монгол, Бидний цөөхөн Монголчууд, CNBC Mongolia, UTV, Талын Монгол, Масс ТВ.
3	Компани тус бүр 1 хуулийн этгээдийн 100% эзэмшилтэй	Тусгай зөвшөөрөл эзэмшигч ХХК-ийг өөр нэг ХХК 100% эзэмшдэг	Acap shop, TV9-2, Asian box, Movie box, MNC, Хөг-Жим, NTV sport, Гандан ТВ, HIT, GoGo TV, N Movies
4	Иргэн + ХК-ийн холимог эзэмшилтэй	Эзэмшигчдийн бүрэлдэхүүнд иргэн болон хувьцаат компани хамт орсон	Mongol TV +1
5	Иргэн, ХХК, НҮТББ (Олон хуулийн этгээдийн холимог эзэмшилтэй)	2 ба түүнээс дээш хуулийн этгээд эзэмшдэг	Dream box, Mon Plus, Глобал ТВ, Блүүмбэрг суваг, Premier sports 1-5 суваг, Лакс ТВ Монгол, TV2, Авто тв

Хүснэгт 8. Арилжааны телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эцсийн эзэмшлийн бүтцийн ангилал

№	Эцсийн эзэмшлийн ангилал	Тоо	Телевизийн нэр
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй (шууд болон дам эзэмшлээр 100%)	32	Парламентын суваг, Channel11, Өлзий телевиз, ТВ5-2, Тэнгэр, Соён гэгээрүүлэгч, TV3, Movietax, LIVE, Хөгжил телевиз, Мянгат Malchin, TV6, News channel, Си чаннель, Их засаг, Mongolsat Кино, GU телевиз, Bantan, MNTV, Play Max, Шүүхийн суваг, Асар shop, TV9-2, Asian box, Movie box, MNC, Хөг-Жим, NTV sport, Гандан ТВ, HIT, GoGo TV, N Movies.
2	Компани тус бүр олон этгээдийн хамтарсан эзэмшилтэй	10	7-р суваг, Eco Channel, Like суваг, Хөх Монгол, Бидний цөөхөн Монголчууд, CNBC Mongolia, UTV, Талын Монгол, Масс ТВ, NTN.
3	Холимог эзэмшилтэй (ХК Иргэн, Иргэн ХХК)	12	Mongol TV +1, Mon Plus, Глобал ТВ, Блүүмбэрг суваг, Premier sports 1-5 суваг, Лакс ТВ Монгол, TV2, Авто тв
4	НҮТББ-ын эзэмшилтэй	1	Dream box

Арилжааны телевизүүдийн эзэмшлийн бүтцийг эцсийн өмчлөгчийн түвшинд авч үзвэл, нийт телевизүүдийн 59 хувь (32 телевиз) нь тус бүр нэг иргэний эзэмшил, хяналтын бүтэцтэй. Бусад нь олон этгээдийн хамтарсан болон холимог эзэмшлийн бүтэцтэй боловч эцсийн өмчлөл мөн цөөн этгээдэд төвлөрсөн шинж ажиглагдаж байна. Энэ нь редакцын хараат бус байдал, бие даасан шийдвэр гаргалтад анхаарах шаардлагатайг илтгэх нэг үзүүлэлт болно.

3. Орон нутгийн телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн байдал

Хүснэгт-9. Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эзэмшлийн бүтэц

№	ХХК-ийн эзэмшлийн бүтэц	Телевизийн тоо
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй	25
2	Компани тус бүр 2 ба түүнээс дээш иргэний хамтарсан эзэмшилтэй	13
3	Компани тус бүр ХХК-ийн дам эзэмшилтэй	1
4	Иргэн болон ХХК-ийн холимог эзэмшилтэй	1
5	Төрийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшилтэй	1

Хүснэгт-10. Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эзэмшлийн бүтэц дэлгэрэнгүй

№	Ангилал	Тайлбар	Телевизийн нэр
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй	Компанийг нэг иргэн дангаар 100% эзэмшдэг	АВ, Тамир, Сайхан Монгол, Номгон, Баянхонгор ТВ, DBS TV, TV4, RGB TV, DSS, Жаран, Дорнын ТВ6, Талын анир ТВ, New broadcasting Television, etv, Мэдээллийн бирж, Гэгээнтэн, SB TV, Төв, Увс, МВС, Олон ястны телевиз, Буян телевиз, D1, Жаргалант ТВ
2	Компани тус бүр 2 ба түүнээс дээш иргэний хамтарсан эзэмшилтэй	2 ба түүнээс дээш иргэн хувьцаа эзэмшдэг	DTV, Дорнод, Мижи, AIR1, Тусгал 1, Хас, Говь HD, BBS TV, TBS, Ховд телевиз, Далай ээж ТВ, Хөвсгөл, Дербес
3	1 хуулийн этгээдийн 100% эзэмшилтэй	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг өөр нэг ХХК 100% эзэмшдэг	TV24
4	Иргэн+ХХК-ийн холимог эзэмшилтэй	Эзэмшигчдийн бүрэлдэхүүнд иргэн болон хуулийн этгээд хамт орсон	Алтан говь ТВ
5	Төрийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшилтэй		Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ

Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдүүдийн 61% нь нэг иргэний эзэмшилтэй, үлдсэн хэсэгт олон иргэний оролцоо бүхий эзэмшил ажиглагдаж байна. Энэ нь орон нутгийн зах зээлийн багтаамж, хөтөлбөрийн онцлог, хүний нөөц, хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал байдалтай холбоотой.

Гэсэн хэдий ч зарим телевизэд олон иргэний оролцоо бүхий эзэмшил нэмэгдэж байгаа нь эзэмшлийн олон талт байдлыг нэмэгдүүлэх боломж байгааг илтгэнэ.

4. Радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эзэмшлийн байдал

Хүснэгт-11. Улаанбаатар хотын радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эзэмшлийн бүтэц

№	ХХК-ийн эзэмшлийн бүтэц	Радиогийн тоо	Радиогийн нэр
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй	18	FM-104.5, FM-107.5, FM-100.5, FM-105.5, FM-98.9, FM-98.1, FM-104, FM-102.5, FM-99.7, FM-96.3, FM-95.7, FM-95.1, FM-96.9, FM-92.5, FM-101.7, FM-92.1, FM-102.1, FM-89.3
2	2 ба түүнээс дээш иргэний хамтарсан эзэмшилтэй, үүнээс 1	6	FM-100.1, FM-106.6, FM-99.3, FM-97.5, FM-89.7, FM-88.3

	нь иргэн, ХХК-ийн хамтарсан эзэмшилтэй		
3	Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг өөр нэг ХХК 100% эзэмшдэг	5	FM-103.6, FM-107.0, FM-91.7, FM-91.1, FM-88.8
4	Иргэн+ТББ-ын холимог эзэмшилтэй (Иргэн-75,5%, ОХУ-ТББ- 24.5%)	1	FM-90.5

Хүснэгт-12. Улаанбаатар хотын радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эцсийн эзэмшлийн бүтцийн ангилал

№	Эцсийн эзэмшлийн ангилал	Тоо	Радиогийн нэр
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй (шууд болон дам эзэмшлээр 100%)	23	FM-104.5, FM-107.5, FM-100.5, FM-105.5, FM-98.9, FM-98.1, FM-104, FM-102.5, FM-99.7, FM-96.3, FM-95.7, FM-95.1, FM-96.9, FM-92.5, FM-101.7, FM-92.1, FM-102.1, FM-89.3, FM-103.6, FM-107.0, FM-91.7, FM-91.1, FM-88.8
2	2 ба түүнээс дээш иргэний хамтарсан эзэмшилтэй, үүнээс 1 нь иргэн, ХХК-ийн хамтарсан эзэмшилтэй	6	FM-100.1, FM-106.6, FM-99.3, FM-97.5, FM-89.7, FM-88.3
3	Иргэн болон ТББ-ын холимог эзэмшилтэй (Иргэн, ОХУ -ын ТББ)	1	FM-90.5

Хүснэгт-13 Орон нутгийн радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эзэмшлийн бүтэц

№	ХХК-ийн эзэмшлийн бүтэц	Радиогийн тоо
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй	22
2	Төрийн бус байгууллагын 100% эзэмшилтэй	8
3	Компани тус бүр 2 ба түүнээс дээш иргэний эзэмшилтэй	2
4	Иргэн, ХХК холимог эзэмшилтэй	1
5	Төрийн өмчийн үйлдвэрийн газрын эзэмшилтэй	1

Хүснэгт-13 Орон нутгийн радиогийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эцсийн эзэмшлийн бүтцийн ангилал

№	Ангилал	Тайлбар	Тоо	Радиогийн нэр
		Компани тус бүрийг нэг иргэн дангаар 100% эзэмшдэг	27	ФМ 89.5, Хөх монгол 87.9, Монгол тандаа зүтгэе залуусын радио FM-87.9, Бизнес радио FM-106.5 (89.1), FM-88.7, Nice radio FM-89.5, Бизнесийн хөтөч FM-89.1, Миний нутаг радио ФМ 89.5, Элгэн нутаг

1	Компани тус бүр 1 иргэний 100 % эзэмшилтэй			87.9, iMongolia radio FM-89.1, Хөх монгол 87.9, Эрдэнэтийн дуу хоолой FM-106.5, Эгшиг радио FM-89.1, Нандин аялгуу 87.5, ФМ 89.1, Төвийн бүсийн радио 87.9, Найс радио FM 89.5, Шинэ дэлхий ФМ 89.1, Хөх монгол 87.9, Тэмүүлэл FM-89.1, Сторм FM-89.1, ФМ 89.1, Буян FM-104.7
2	2 ба түүнээс дээш иргэний хамтарсан эзэмшилтэй	2 ба түүнээс дээш иргэн хувьцаа эзэмшдэг	5	Төрөлх Алтай фм 89.5, Бизнесийн хөтөч FM-89.1, Ноён уул радио FM-102.6, Баянзам FM-101.1, Тал нутгийн аялгуу ФМ 87.9
3	Төрийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшилтэй		1	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ
4	Иргэн+ХХК-ийн холимог эзэмшил	Эзэмшигчдийн бүрэлдэхүүнд иргэн болон хуулийн этгээд хамт орсон	1	Миний говь FM-89.1

Улаанбаатар хот болон орон нутгийн радиогийн хувьд нэг иргэний шууд ба шууд бус эзэмшил давамгайл байна. Нийт радиогийн 75 орчим хувь нь нэг иргэний эзэмшил, хяналттай байгаа нь өмчлөлийн хяналт хувь хүний түвшинд түгээмэл байгааг илтгэнэ. Мөн радиогийн салбарт телевизтэй харьцуулахад төрийн бус байгууллагын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг эзэмшлийн онцлог ажиглагдаж байна.

5. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч эзэмшигчдийн эзэмшлийн байдал

Хүснэгт-14 Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн эзэмшлийн бүтэц

№	ХХК-ийн эзэмшлийн бүтэц (Улаанбаатар хот)	ОСДҮ эрхлэгчдийн тоо
1	Компани тус бүр нэг 1 иргэний 100% эзэмшилтэй	2
2	Компани тус бүр 1 хуулийн этгээдийн 100% эзэмшилтэй (хуулийн этгээд нь хэд хэдэн хөрөнгө оруулагчтай)	5
3	Компани тус бүр иргэн, ХХК-ийн холимог эзэмшилтэй	2
4	Гадаадын хөрөнгө оруулалттай ХХК-ийн оролцоотой хамтарсан эзэмшилтэй (2ХХК хамтран эзэмшдэг, үүнд гадаадын хөрөнгө оруулалттай-ӨМӨЗО-ны Лунбан Сүлжээний технологи - 32%)	1
5	Хувьцаат компанийн эзэмшилтэй Төрийн өмчит болон олон нийтийн оролцоотой (Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар-94.7%, олон нийт-5.3 %)	1

№	ХХК-ийн эзэмшлийн бүтэц (Орон нутаг)	ОСДҮЭ тоо
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй	11
2	Компани тус бүр 2 ба түүнээс дээш иргэний эзэмшилтэй	3

Хүснэгт-15. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эцсийн эзэмшлийн бүтцийн ангилал

№	Ангилал	Тайлбар (Улаанбаатар хот)	ОСДҮЭ
1	Компани тус бүрийг 1 иргэн 100% эзэмшдэг	Компанийг нэг иргэн дангаар 100% эзэмшдэг	Оптимум КаТВ, Mongolsat
2	Компани тус бүрийг 1 хуулийн этгээд 100% эзэмшдэг	Тусгай зөвшөөрөл эзэмшигч ХХК-ийг өөр нэг ХХК/ХК 100% эзэмшдэг	ORI, Хөдөлгөөнт Телевиз, Skymedia, VOO, Univision
3	Иргэн+ХХК-ын холимог эзэмшилтэй	Эзэмшигчдийн бүрэлдэхүүнд иргэн болон хуулийн этгээд хамт орсон	Ddish, Beyond Media, MNBC,
4	Гадаадын хөрөнгө оруулалттай ХХК -ийн эзэмшилтэй	<i>2ХХК хамтран эзэмшдэг, үүнд гадаадын хөрөнгө оруулалттай-ӨМӨЗО-ны Лунбан Сүлжээний технологи - 32%</i>	Шинэ сансар кабель ХХК
5	Хувьцаат компанийн эзэмшилтэй (Төрийн өмчит болон олон нийтийн)		National КаТВ
№	Ангилал	Тайлбар (Орон нутаг)	ОСДҮЭ
1	Компани тус бүр 1 иргэний 100% эзэмшилтэй	Компанийг нэг иргэн дангаар 100% эзэмшдэг	Эм Эм Ди Эс КаТВ, Ди Би Эс КаТВ, Мэргэшир-Од КаТВ, Цацраг трэйд КаТВ, Дархан ширхэнцэг КаТВ, Стар КаТВ, Орхон системс КаТВ, Би Ти Жи КаТВ, Дөрвөн шарга КаТВ, Дөрвөн шарга КаТВ, ТОД caTV
2	Компани тус бүр 1 хуулийн этгээдийн 100% эзэмшилтэй	Тусгай зөвшөөрөл эзэмшигч ХХК-ийг өөр нэг ХХК/ХК 100% эзэмшдэг	ЖСММ КаТВ, ЖСММ КаТВ, Өндөр Мандал КаТВ

Улаанбаатар хотын олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн бүтцийг авч үзвэл, дан эзэмшлээс илүү хуулийн этгээд болон холимог хэлбэр давамгайлсан, эцсийн өмчлөгчийн түвшинд олон хөрөнгө оруулагчийн оролцоотой, харьцангуй нийлмэл бүтэц давамгайлж байна.

Хэд хэдэн телевиз, радио, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхэлдэг компанийн нэгдлийн бүтэц, хамаарал

Хүснэгт 16. Компаниудын хамаарал бүхий телевиз, радио, олон суваг дамжуулах үйлчилгээний мэдээллийг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

№	Медиа групп/ Байгууллага	Тусгай зөвшөөрлийн нэр	Үйлчилгээний нэр
1	Гэр контент групп ХХК Монголмасс Медиа (Д.Баясгалан-100%) эцсийн өмчлөгч	Өргөн нэвтрүүлгийн телевиз	Боловсрол-100%; Ийгл телевиз- 100%;
		Арилжааны телевиз	Asar shop; Asian box; Movie box; Хөг- жим; MovieBoxPlus;
		Радио	Цаг үе залуус FM 91.1
2	Медиагрупп ХХК (Шунхлай Холдинг ХХК-100%) эцсийн өмчлөгч	Өргөн нэвтрүүлгийн телевиз	NTV
		Арилжааны телевиз	NTV Спорт, N Movies
		Төлбөртэй	MN+, Sky Live
		ОСДҮЭ	Skymedia
		Радио	Эх дэлхий FM 107-(ХЭ:91.49%)
3	Миллениум Групп ХХК (Э.Батшугар-100%) эцсийн өмчлөгч	Өргөн нэвтрүүлгийн телевиз	TV9
		Арилжааны телевиз	TV9-2 (Кино суваг)
		Радио	Тэнгэрлэг радио FM 103.6
4	Гэгээн Далай ХХК (Н.Базаррагчаа-100%)	Өргөн нэвтрүүлгийн телевиз	TV5
		Арилжааны телевиз	TV5-2; Moviemax
5	Супер Вижн Медиа Групп ХХК (С.Болдхэт-100%) эцсийн өмчлөгч	Өргөн нэвтрүүлгийн телевиз	SBN
		Арилжааны телевиз	Mon Plus
6	Тэнгэрлиг Медиа Групп	Өргөн нэвтрүүлгийн телевиз	Монгол TV-(ХЭ:20%) TenGer TV-(ХЭ:80%)
		Арилжааны телевиз	Mongol TV ⁺ (ХЭ:20%)
		ОСДҮЭ	ORI (ХЭ:20%)
7	Контент Дистрибушн ХХК	Арилжааны телевиз	SPS National; SPS Fight; SPS World; SPS Classic; SPS Prime-(ХЭ-70%)
		Төлбөртэй	UniSport 1; UniSport 2; Юнилайв 88; (ХЭ:100%)
		ОСДҮЭ	Ddish(ХЭ:49%); Univision(ХЭ:100%)
8	Вайлинг ХХК (Суббэ)	Арилжааны телевиз	902 Kids; 903 HITS; 900 Кино (ХЭ:100%)
9	Малчин Удамын Хийморь ХХКН. (Ням-Осор-100%)	Өргөн нэвтрүүлгийн телевиз	Малчин;
		Арилжааны телевиз	Их Засаг
10	Улаанбаатар Телевиз ХХК	Өргөн нэвтрүүлгийн телевиз	UBS(ХЭ:100%)
		Арилжааны телевиз	Глобал TV(ХЭ:75.5%)

11	Номадиа Нэтворк ХХК (Ц.Пүрэвдорж-100%)	Төлбөртэй	Монгол кино; Монгол суваг; Шинэ кино; Ddishлайв; DDISHMUSIC
12	Монвсат Нэтворк ХХК (Ч.Доржпагам-100%)	Арилжааны телевиз	Mongolsat Кино(ХЭ:100%)
		Төлбөртэй	900 Төлбөрт үзвэр; 996 Шилдэг кино; 997 Монгол кино; TV Театр 999; TV Театр 995
13	Монгол контент ХХК (Мобиком Корпораци ХХК-100%)	Арилжааны телевиз	GoGo TV
		Төлбөртэй	VOO Max

Өнөөгийн байдлаар дээрх 13 компанийн хүрээнд нийт 50 телевизийн тусгай зөвшөөрөл бүртгэгдсэнээс 10 нь өргөн нэвтрүүлгийн телевиз, 24 нь арилжааны телевиз, 16 нь төлбөртэй телевиз, 4 нь олон суваг дамжуулах үйлчилгээ, 3 нь радио үйлчилгээ байна.

График:1 Эзэмшлийн шууд болон шууд бус хамаарал бүхий телевиз, радио, олон суваг дамжуулах үйлчилгээний бүтэц



Хүснэгт 17: Монголмасс Медиа ХХК-ийн компанийн нэгдэл, эзэмшлийн бүтэц

	№	100% хөрөнгө оруулалттай компани	Охин компани	Эзэмшлийн хувь	Холбогдох тв/радио	Үйлчилгээний төрөл
Монгол масс Медиа ХХК		Гэр контент групп ХХК	Медиа боловсрол суваг ХХК	100%	Боловсрол суваг ТВ	Өргөн нэвтрүүлгийн телевиз
			Эйшн бокс ХХК	100%	Asian box	Арилжааны телевиз

	1		Мөүви бокс ХХК	100%	Movie box	Арилжааны телевиз
			Мөүви бокс плас ХХК	100%	Movie box plus	Төлбөрт телевиз
	2	Монголиа Медиа Корпорэйшн ХХК	Ийгл бродкастинг ХХК	100%	Eagle TV	Өргөн нэвтрүүлгийн телевиз
			Шууд ТВ ХХК	100%	Асар шоп	Арилжааны телевиз
			Монгол комикс ХХК	100%	FM 91.1	Радиоогийн үйлчилгээ
	3	Мюзик бокс ХХК		100%	Хөгжим	Арилжааны телевиз

Монголмасс Медиа ХХК-ийн эзэмшлийн бүтцээс үзэхэд тус компани нь 100 хувь эзэмшилтэй охин компаниудаараа дамжуулан телевиз, радиоогийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Хүснэгт 18: Шунхлай холдинг ХХК-ийн компанийн нэгдэл, эзэмшлийн бүтэц

	№	100% хөрөнгө оруулалттай компани	Охин компани	Охин компани	Эзэмшлийн хувь	Телевиз, радиоогийн нэр	Үйлчилгээний төрөл
Шунхлай холдинг ХХК	1	Медиа групп ХХК	Эн Ти Ви Бродкастинг ХХК	-	100 %	NTV	Өргөн нэвтрүүлгийн телевиз
				-	100 %	N Movies	Арилжааны телевиз
				И Зэт Эф Эм ХХК	100 %	Эх дэлхий ФМ 107	Радиоогийн үйлчилгээ
			Монзах ХХК	-	100 %	NTV sport	Арилжааны телевиз
	2	Скайтел ХХК	100 %			MN+	Төлбөрт тв
						Sky live	Төлбөрт тв
						Skymedia	ОСДҮЭ

Хүснэгт 19: Тэнгэрлиг Медиа Групп компанийн нэгдэл, эзэмшлийн бүтэц

	№	Хөрөнгө оруулалт	Охин компани	Эзэмшлийн хувь	Холбогдох тв/радио	Үйлчилгээний төрөл
	1	Монгол телевиз ХХК	20%		Монгол ТВ	Өргөн нэвтрүүлгийн телевиз
					Mongol TV +1	Арилжааны телевиз

Тэнгэрлиг Медиа групп ХК			Оримедиа ХХК	100%	ORI	ОСДҮЭ
	2	Про медиа нетворк ХХК	80%		TenGer TV	Өргөн нэвтрүүлгийн телевиз

Хүснэгт 20: Контент Дистрибьюшн ХХК-ийн компанийн нэгдэл, эзэмшлийн бүтэц

	№	100% хөрөнгө оруулалттай компани	Охин компани	Эзэмшлийн хувь	Холбогдох тв/радио	Үйлчилгээний төрөл
Контент дистрибьюшн ХХК	1	Премьер спортс ноотоор ХХК		70%	Premier sports 1-5	Арилжааны телевиз
	2	Юнител ХХК	-	100%	UniSport 1	Төлбөрт телевиз
					UniSport 2	
					Юнилайв 88	
			Юнивишн ХХК	100%	Univision	ОСДҮЭ
ДДэш ТВ ХХК	49%	Ddish	ОСДҮЭ			

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн бүтцийг нийтэд нь авч үзвэл нэг иргэн буюу нэг этгээдийн эзэмшил давамгай (нийт 133 үйлчилгээ эрхлэгч) байна. Харин хоёр болон түүнээс дээш эзэмшигчтэй байгууллага харьцангуй цөөн байгаа нь олон талт оролцоо хязгаарлагдмал байгааг илтгэнэ.

Цаашид өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн бүтцэд тогтмол үнэлгээ, дүн шинжилгээ хийж, эцсийн өмчлөлийн ил тод байдлыг хангах шаардлагатай.

Гэвч Өргөн нэвтрүүлгийн тухай хууль-ийн 18.2, 19.4-т зах зээлийн хэт төвлөрлөөс сэргийлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх хуулийн заалт хэтэрхий ерөнхий шинжтэй тул журмаар нарийвчлан зохицуулах боломж хязгаарлагдмал байна.

Иймд бодитоор хэт төвлөрөл үүссэн эсэхийг үнэлж үзэх, эзэмшлийн хэт төвлөрлийг эцсийн өмчлөгчийн түвшинд тодорхойлох, зах зээлийн хэт төвлөрлийн түвшинг үнэлэх шалгуур, аргачлалыг хуульд тодорхой тусгах, холбогдох эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, чиг үүргийг тодорхой болгох зэрэг зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгаж, боловсронгуй болгох шаардлагатай.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй <https://shorturl.at/gbYsD> холбоосоор орж танилцана уу.